



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 455

Улаанбаатар хот

Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газар болон харьяа газар, хэлтсийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2. Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар болон харьяа газар, хэлтсийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашины ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 16 өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР БОЛОН ХАРЬЯА ХЭЛТСИЙН
ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ
АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Байгууллагын нэр	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Стандарт, хэмжил зүйн газар	Үйлчилгээний автомашин	Тусгай зориулалтаар тоноглогдсон /Микро/	3
			Хот доторх ажлын суудлын автомашин	1
2	Архангай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин /микро/	1
3	Баянхонгор аймаг дахь Стандарт хэмжил зүйн хэлтэс			1
4	Баян-Өлгий аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
5	Булган аймаг дахь Стандарт хэмжил зүйн хэлтэс			1
6	Говь-Алтай аймаг дахь Стандарт хэмжил зүйн хэлтэс			1
7	Говьсүмбэр аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
8	Дархан-Уул аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
9	Дорноговь дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1

10	Дорнод дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин /микро/	1
11	Дундговь дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
12	Завхан дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
13	Орхон дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
14	Өвөрхангай дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
15	Өмнөговь дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
16	Сүхбаатар дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
17	Сэлэнгэ дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
18	Төв дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
19	Увс дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
20	Ховд дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
21	Хөвсгөл дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
22	Хэнтий дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс			1
23	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори			2
Нийт автомашин				27